

ТАТВАРГҮЙ БАРААНЫ ДЭЛГҮҮРИЙН СОНГОН  
ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ, ЗӨВШӨӨРӨЛ  
ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гаалийн нутаг дэвсгэр дээр татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулалт зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Хилээр нэвтрэх зорчигчдод үйлчлэх татваргүй барааны дэлгүүрийг олон улсын нисэх буудал, хилийн боомтод, Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын болон олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдлэх албан тушаалтанд үйлчлэх татваргүй барааны дэлгүүрийг гаалийн нутаг дэвсгэрийн гүнд байгуулж болно.

1.3.Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах сонирхол бүхий Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн дунд сонгон шалгаруулалтын үндсэн дээр татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрөл олгоно.

1.4.Энэ журмын 1.2-т заасан байршлуудад татваргүй барааны дэлгүүр ажиллуулах, эсхүл татваргүй барааны дэлгүүрийн тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн тохиолдолд гаалийн байгууллага сонгон шалгаруулалт зохион байгуулна.

1.5.Татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгохтой холбогдсон энэ журмаар зохицуулаагүй бусад асуудлыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Гаалийн тухай хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

Хоёр. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах.

2.1.Сонгон шалгаруулалтыг Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар байгуулагдсан комисс зохион байгуулна.

2.2.Сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

2.3.Сонгон шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй зарлах бөгөөд сонирхсон этгээдэд саадгүй олгоно.

2.4.Сонгон шалгаруулалтын урилгад дараах мэдээллийг тусгана:

2.4.1.сонгон шалгаруулалт зарлаж буй татваргүй барааны дэлгүүрийн байршил, тоо;

2.4.2.сонгон шалгаруулалтын бичиг баримт, бусад мэдээлэл авах хаяг;

2.4.3.сонгон шалгаруулалтын бичиг баримтын үнэ;

2.4.4.сонгон шалгаруулалтын бичиг баримт хүлээн авах эцсийн хугацаа;

2.4.5.сонгон шалгаруулалтыг нээх хугацаа.

2.5.Сонгон шалгаруулалтын бичиг баримт /цаашид бичиг баримт гэх/-ыг сонгон шалгаруулалтын урилга нийтлэгдэх өдрөөс өмнө бэлэн болгосон байна.

2.6.Бичиг баримтыг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах өртгөөр үнэлж, оролцогчдод уг үнээр саадгүй худалдана.

2.7.Сонгон шалгаруулалтад оролцогч бичиг баримтыг хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалттай холбоотой нэмэлт мэдээлэл авахаар гаалийн байгууллагад бичгээр хүсэлт гаргаж болно.

2.8.Бичиг баримтыг хүлээн авах эцсийн хугацааг сонгон шалгаруулалтыг анх зарлан мэдээлсэн өдрөөс эхлэн хуанлийн 30 хоногоор тогтооно.

2.9.Бичиг баримтыг нээснээс хойш тухайн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж дуусгах хугацааг гаалийн удирдах төв байгууллага тогтоож, сонгон шалгаруулалтын урилга, бичиг баримтад тусгах бөгөөд уг хугацаанд сонгон шалгаруулалт хүчинтэй байна.

2.10.Сонгон шалгаруулалтад оролцогч аж ахуйн нэгжүүд сонгон шалгаруулалтын баталгаа болгож, банкны байгууллагаар 1000 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн баталгааг 1 жилийн хугацаатай гаргуулсан байна.

2.11.Сонгон шалгаруулалтад оролцогч сонгон шалгаруулалтын материалын эх хувь болон хуулбар хувийг тус бүрт нь дугтуйнд хийж, битүүмжлэн сонгон шалгаруулалт зохион байгуулах комисст хүлээлгэн өгнө. Дугтуйн дээр сонгон шалгаруулалтад оролцох аж ахуйн нэгжийн нэр, хаяг, утас, захирлын нэрийг бичсэн байна.

2.12.Дараах тохиолдолд сонгон шалгаруулалтын бичиг баримтыг хүлээж авахгүй бөгөөд хаягаар нь буцаана:

2.12.1.сонгон шалгаруулалтын бичиг баримтыг худалдаж аваагүй аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн;

2.12.2.зарласан хугацаанаас хоцорч ирүүлсэн.

2.13.Дараах тохиолдолд сонгон шалгаруулалтын бичиг баримтыг хүчингүйд тооцож, сонгон шалгаруулалтанд оруулахгүй:

2.13.1.сонгон шалгаруулалтын бичиг баримтад заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй;

2.13.2.сүүлийн 3 жилийн хугацаанд татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа явуулж байхдаа гэрээний үүрэг, дэлгүүрт тавигдах нөхцөл, шаардлагыг зөрчсөн, гаалийн хууль тогтоомжийн зөрчил удаа дараа гаргаж байсан.

2.14.Дараах тохиолдолд банкны баталгаа хүчингүй болгох мэдэгдлийг гаалийн ерөнхий газраас олгоно:

2.14.1.энэ журмын 2.12, 2.13, 4.1.2, 4.1.3-т заасан үндэслэлээр сонгон шалгаруулалтад оролцоогүй;

2.14.2.сонгон шалгаруулалтад оролцогч сонгон шалгаруулалтад шалгараагүй.

2.15.Дараах тохиолдолд сонгон шалгаруулалтын баталгааг улсын орлого болгоно:

2.15.1.сонгон шалгаруулалтад оролцогч сонгон шалгаруулалтыг нээсний дараа, сонгон шалгаруулалтын хүчинтэй хугацаа дуусахаас өмнө өөрийн сонгон шалгаруулалтаас татгалзсан;

2.15.2.сонгон шалгаруулалтад шалгарсан аж ахуйн нэгж татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаас хойш энэ журмын 5.6 дахь хэсэгт заасан хугацаанд үйл ажиллагаа явуулж эхлээгүй.

2.16.Сонгон шалгаруулалтад шалгарсан аж ахуйн нэгжийн банкны баталгаа нь энэ журмын 2.10-д заасан хугацаанд хүчинтэй байх ба энэ хугацаа дуусахад аж ахуйн нэгжийн банкны баталгаа хүчингүй болно.

#### Гурав. Сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлт

3.1.Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах сонирхол бүхий Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:

3.1.1.тухайн аж ахуйн нэгж нь эрх бүхий аудитаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан баланс, дансны хуулгаар санхүүгийн чадавхитай болохоо нотолсон байхаас гадна өөрийн хөрөнгийн хэмжээ нь 1,000,000 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөс доошгүй болохыг баталгаажуулсан банк, татварын байгууллагын тодорхойлолт, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний нотариатоор гэрчлүүлсэн хуулбарыг тус тус хавсаргасан байх;

3.1.2.татваргүй барааны дэлгүүрүүдэд бараа нийлүүлдэг олон улсын тавцанд нэр хүнд бүхий нийлүүлэгч компаниас бараагаа тогтмол нийлүүлэх талаар гэрээ байгуулсан, татваргүй барааны дэлгүүрт нийлүүлэгдэх барааны загвар, гэрэл зургийг харуулсан католог, альбом хавсаргасан байх;

3.1.3.татваргүй барааны дэлгүүр ажиллуулах худалдааны танхимын талбайн хэмжээ, тавилга, гэрэлтүүлэг, бараа хадгалах агуулах, туслах өрөөний байрлалыг харуулсан схем, зураглал нь гаалийн хяналтыг хэрэгжүүлэх, гаалийн байгууллагаас худалдааны танхим, байр агуулахыг хяналтын камераар хянах нөхцлийг бүрдүүлсэн байх;

3.1.4.тухайн аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагч болон гүйцэтгэх удирдлага нь гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгүүлээгүй, сүүлийн 3 жилийн хугацаанд Монгол Улсын гаалийн тухай хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжийг зөрчөөгүй байх ба энэ тухай цагдаа, гааль, татварын байгууллагын тодорхойлолтоор нотлох;

3.1.5. татваргүй барааны дэлгүүрт орсон барааг гаалийн байгууллагын хяналтгүй худалдаалахгүй байх талаар баталгаа гаргасан байх;

3.1.6. компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар гэрчлүүлсэн байх;

3.1.7. олон улсын нисэх буудалд татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тохиолдолд татваргүй барааны дэлгүүрийн зориулалтаар үйл ажиллагаа явуулах талбай олгох талаар нисэх буудлын захиргаанаас албан бичиг авсан байх;

3.1.8. хилийн боомтод татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тохиолдолд татваргүй барааны дэлгүүрийн зориулалтаар үйл ажиллагаа явуулах талбай олгох талаар эрх бүхий байгууллагаас албан бичиг авсан байх;

3.1.9. татваргүй барааны дэлгүүрийг гаалийн нутаг дэвсгэрийн гүнд ажиллуулах тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргасан байх;

3.1.10. татварын өргүй буюу татварын албанаас ногдуулсан татварыг тогтоосон хугацаанд нь төлсөн байх;

3.1.11. нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй буюу даатгалын шимтгэлийг хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын санд төлсөн байх;

3.1.12. хугацаа хэтэрсэн зээлийн өргүй, зээлтэй тохиолдолд зээлийн эргэн төлөлтүүд хугацаандаа хийгдсэн байх;

3.1.13. сонгон шалгаруулалтад оролцогч аж ахуйн нэгжийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтны боловсрол, мэргэжлийн ур чадварын талаар танилцуулга бэлтгэж, хавсаргасан байна.

#### Дөрөв. Сонгон шалгаруулалтыг нээх, үнэлэх

4.1. Татваргүй барааны дэлгүүрийн сонгон шалгаруулалтыг шалгаруулах комисс нь сонгон шалгаруулалтыг дараах байдлаар нээнэ. Үүнд:

4.1.1. сонгон шалгаруулалтад оролцогч аж ахуйн нэгжийн төлөөллийг байлцуулан сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн материалын эх хувийг нээж, журмын 3.1.1-3.1.13-т заасан шалгуур үзүүлэлтийг хангасан болохыг нотлох бичиг баримтыг нягтлан шалгаж, дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөх ба иж бүрдэл нь бүрэн бол тухайн саналыг хүлээн авна.

4.1.2. хэрэв сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн материалд энэ журмын 3.1.1-3.1.13-т заасан бичиг баримт дутуу бол тухайн саналыг хүчингүйд тооцон, энэ тухай тэмдэглэл үйлдэж, сонгон шалгаруулалтад оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчид буцаан өгнө.

4.1.3. саналаа ирүүлсэн сонгон шалгаруулалтад оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь урилгад заасан газар болон цаг хугацаанд хүрэлцэн ирээгүй бол саналыг задлахгүйгээр хүчингүйд тооцож оролцогчид бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш ажлын 3 өдөрт багтаан сонгон шалгаруулалтад оролцохоор битүүмжлэн ирүүлсэн саналыг тухайн

оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хүлээн аваагүй бол энэ тухай тэмдэглэл үйлдэн журмын 2.11-д заасан шуудангийн хаягаар буцаан хүргүүлнэ.

4.2.Татваргүй барааны дэлгүүрийн сонгон шалгаруулалтыг шалгаруулах комисс нь сонгон шалгаруулалтыг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

4.2.1.комисс материалыг хуанлийн 21 хоногт нягтлан шалгаж, үнэлнэ;

4.2.2.комисс сонгон шалгаруулалтад оролцогчдын материалыг үнэлэхдээ оролцогч аж ахуйн нэгжээс ирүүлсэн саналд энэ журмын 3.1.1-3.1.13-т заасан шалгуур үзүүлэлт тус бүрээр комиссын гишүүн бүр 0-5 оноо өгнө;

4.2.3.комиссын гишүүд үзүүлэлт бүрт үнэлгээ өгч, дундаж үнэлгээг гаргана;

4.2.4.сонгон шалгаруулалтад оролцсон хоёр болон түүнээс дээш оролцогч нь адил үнэлгээ авсан бол хүсэлтээ хамгийн түрүүнд бүртгүүлсэн оролцогчид зөвшөөрөл олгох тухай дүгнэлтийг гаргана.

4.2.5.дундаж үнэлгээ нь нийт авах онооны 50 хувиас дээш байх бөгөөд хамгийн өндөр оноо авсан дарааллаар байр эзлүүлэн дүгнэнэ.

#### Тав. Зөвшөөрөл олгох

5.1.Сонгон шалгаруулалтын дүнг Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэнэ.

5.2.Сонгон шалгаруулалтын комиссын нэгдсэн дүгнэлт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогчид мэдэгдлийг, харин бусад оролцогч нарт шалгараагүй үндэслэлийг дурдсан мэдэгдлийг энэ журмын 2.11-д заасан холбоо барих утсаар болон хаягаар шаардлагатай бол цахим шуудангийн хаягаар мэдэгдэнэ.

5.3.Сонгон шалгаруулалтаар шалгарсан аж ахуйн нэгж нь Гаалийн ерөнхий газраас мэдэгдэл авсан өдрөөс хойш 3 сарын дотор дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна.Үүнд:

5.3.1.татваргүй барааны дэлгүүр ажиллуулах худалдааны танхимд тавилга, тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, агааржуулалт, хадгалалтын тусгай нөхцөл шаардагдах бараа хадгалах зориулалтын тоног төхөөрөмж байрлуулж, өндөр зэрэглэлийн үйлчилгээ үзүүлэх тохилог орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх;

5.3.2.бараа бүтээгдэхүүн хадгалах агуулахад чийглэг, температурыг хэмжих хэрэгсэл байрлуулж, галын дохиоллын систем, гал унтраагч төхөөрөмжөөр тоноглон, холбогдох байгууллагын дүгнэлтийг гаргуулсан байх;

5.3.3.гаалийн байгууллагатай гаалийн нэгдсэн онлайн сүлжээгээр холбогдож, барааны бүртгэлд GS1 системийг нэвтрүүлсэн байх;

5.3.4.татваргүй барааны дэлгүүр, агуулахад хяналтын камерыг бараа, ажил, үйлчилгээ бүхэлдээ харагдах газарт шаардлагатай тоо хэмжээгээр

байрлуулж, бичлэгийг гаалийн хяналтын зорилгоор ашиглах шаардлага хангахуйц түвшинд хийж, хяналтын нийтлэг журамд заасан хугацаанд хадгалж, гаалийн байгууллагаас шаардсан хугацаанд гаргаж өгөх боломжийг бүрдүүлсэн байх;

5.3.5.дэлгүүрт худалдаалах барааны гарал үүсэл, чанарыг тодорхойлсон бичиг баримтыг бүрдүүлсэн байх;

5.3.6.татваргүй барааны дэлгүүрт нийлүүлэгдэх барааны хайрцаг, шошго дээр “Mongolian duty not paid” гэсэн дардастай байх;

5.3.7.энэ журмын 3.1.2-т заасан гэрээний дагуу барааг улсын хилээр оруулсан байх;

5.3.8.татваргүй барааны дэлгүүрт хяналт, шалгалтыг хэвийн явуулах техник хэрэгсэл болон гаалийн улсын байцаагчийн ажиллах нөхцлийг хангасан байх.

5.4.Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрөл авах аж ахуйн нэгж нь журмын 5.3.1-5.3.8-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан талаар Гаалийн ерөнхий газарт албан бичгээр мэдэгдэнэ. Журамд заасан нөхцөл, шаардлага хангасан эсэхийг гаалийн байгууллага шалгана.

5.5.Журмын шаардлага хангасан тохиолдолд татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар олгоно.

5.6.Зөвшөөрөл олгосноос хойш 3 сарын дотор үйл ажиллагаагаа эхлүүлээгүй тохиолдолд зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

#### Зургаа. Бусад

6.1.Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрлийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлэхийг хориглоно.